



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/11

Мандалговь

Биеийн тамир, спорт хамтлаг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйл, 21 дүгээр зүйл, Засгийн газрын 2009 оны “Нийтийн биеийн тамир спортын талаар авах зарим арга хэмжээний тухай” 05 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Биеийн тамир, спортын газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 23 өдрийн А/82 тушаал “Спорт хамтлаг байгуулах тухай дүрэм”-ийн 1 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын биеийн тамир, спорт хамтлагийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутаг, төрийн бус байгууллага, хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

2. Тус газрын ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, биеийн тамир спортын техник хэрэгсэлтэй харьцах харилцааг нэмэгдүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар тодорхой чиглэл, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биеийн тамир, спортын тэргүүний хамтлагийн болзлыг ханган ажиллахыг (А. Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Хамтлагаас зохион байгуулсан ажилд идэвхтэй хамрагдаж, 7 хоног бүр биеийн тамираар хичээллэж байхыг нийт албан хаагчдад уриалсугай.

ДАРГА



Н.ГАНТУЛГА

Tuhsaal A.docx

482191929